



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 264

Улаанбаатар хот

“Булган АЗЗА” төрийн өмчит
хувьцаат компанийн 2019 оны үйл ажиллагаа,
эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин
болон контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.1 дэх заалт, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Булган АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон гүйцэтгэх захирал Б.Батсайхантай байгуулсан 2019 оны контрактын биелэлтийг “Хангалтгүй” гэж дүгнэсүгэй.

2. “Булган АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Батсайхантай байгуулсан контрактын гэрээг дуусгавар болгох, компанийн хэвийн үйл ажиллагааг хангах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

000519